



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 01

Хажуу шинэ үе

Амьжиргааг дэмжих зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.5 дахь заалт, Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1. Сумын амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Зөвлөлийн дарга: Г.Эрдэнэцэцэг /ЗДТГ-ын дарга/

Гишүүд: Х.Отгончимэг /2-р багийн эмч/

Б.Гүнсмаа /Ахмадын хорооны дарга/

Д.Жаргалмаа /Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга/

М.Ундрах /Иргэдийн төлөөлөл/

С.Пүрэвсүрэн /Иргэдийн төлөөлөл/

Нарийн бичгийн дарга: Н.Өлзийтогтох /Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

2. Хууль, дүрмийн дагуу ажиллаж, тайлангаа хагас бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг зөвлөлийн дарга-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 11 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА *[Signature]* В.НЯМСҮРЭН

040001



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 02

Хажуу шинэ үс

Г Дашзэвгийн Лхамсүрэнг “Алтан гадас” одонгоор шагнуулах тухай Г

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журмын 12-ын “Г”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дах заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ НЬ :

1.Тус сумын 1 дүгээр багийн иргэн Дашзэвгийн Лхамсүрэнгийн мал аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан хөдөлмөр бүтээлийг нь үнэлж Монгол Улсын төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2. Тодорхойлолт материалуудыг аймгийн нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэхийг сумын Засаг дарга /Ө.Мөнх-Амгалан/-д үүрэг болгосугай.



ДАРГА *Ө.Мөнх-Амгалан* В.НЯМСҮРЭН

040003



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 03

Хажуу шинэ үс

Эд хөрөнгийг бүртгэх, данснаас
хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3.а заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3 дэхь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолын хавсралтаар баталсан орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1.Сумын төсөвт албан байгууллагуудын 2018 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон төсвийн хөрөнгөөр бэлтгэгдсэн эд хөрөнгийг үндсэн хөрөнгийн бүртгэлд авах жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг акталж, данснаас хасах жагсаалтыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6,7,9 дүгээр зүйлд заасны дагуу тухайн байгууллагынхаа хөрөнгийн бүртгэлд бүртгэж, тайлан блансдаа тусган, өмч хөрөнгийн эзэмшил, хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ТЭРГҮҮЛЭГЧ  Б.ЦЭРЭНМӨНХ



040006

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 01 сарын 16 өдрийн 03
дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Төсөвт албан байгууллагуудын шинээр бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Эх үүсвэр
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал						
1	Нөтбүүк	ш	1	1635000	1635000	Төсөв
2	Өнгөт принтер	ш	1	960000	960000	
	Нийт дүн				2595,000	
Засаг даргын тамгын газар						
1	Бунхант ЦДАШ	ш	1	9613,225	9613,225	ОНХС
2	Булшин худаг	ш	1	5000.000	5000.000	
3	Нартын хүн овоот худаг	ш	1	5000.000	5000.000	
4	Ширээ	ш	3	514000	1542,000	Төсвийн хөрөнгөөр
5	Хаалт	ш	3	237000	713,100	
6	Шүүгээ	ш	3	310300	930,900	
7	Ширээ	ш	10	213,300	2133,000	
8	Сандал	ш	30	69700	2091,000	
9	Ширээ	ш	1	562500	562500	
10	Шүүгээ	ш	1	339400	339400	
11	Сандал	ш	3	169700	509,100	
12	Сандал	ш	1	320000,	320000,	
13	Ширээ	ш	1	591600	591600	
14	Нөтбүүк	ш	2	1801400	3602,800	
15	Процессор	ш	1	1170,400	1170,400	
16	Принтер	ш	1	389,900	389,900	
17	Иж бүрэн компьютер	ш	1	1730,000	1730,000	
18	Процессор	ш	1	1400,000	1400,000	
19	Нөтбүүк	ш	1	1600,000	1600,000	
20	Хөлдөөгч	ш	1	449900	449900	
21	Усны аппарат	ш	2	199900	399800	
	Нийт дүн				40,088,625	
Цэцэрлэг						
1	Принтер	ш	1	476,000	476,000	Төсвийн хөрөнгөөр
2	Сандал	ш	1	169,700	169,700	
3	Тоос сорогч	ш	4	261,800	1047,200	
4	Сандал	ш	10	72700	727,000	
5	Зөөврийн яригч	ш	1	150,000	150,000	
6	Дрож	м	7	60,000	420,000	
	Дүн				2989,900	

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 04 сарын 16 өдрийн 23
дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**Төсөвт албан байгууллагын акталж, данснаас хасах хөрөнгийн
жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Блансын үнэ	Тайлбар
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал						
1	Телевизор	ш	1	389,570	389570	Хоцрогдсон
	Дүн				389570	
Засаг даргын тамгын газар						
1	Ширээ	ш	1	550,000	550,000	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон
2	Компьютер	ш	1	569,601	569,601	
3	Компьютер	ш	1	1000,000	1000,000	
4	Компьютер	ш	1	639,999,8	639,999,8	
5	Хөргөгч	ш	1	256,410	256,410	
6	Хивс	ш	1	81,405	81,405	
	Дүн			3097,415,8	3097,415,8	
Цэцэрлэг						
1	Ширээ	ш	2	50,000	100,000	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон
2	Сандал	Ш	5	25,000	125,000	
3	Сандал	ш	4	26400	105,600	
	Дүн				330,600	
Сум дундын эмнэлэг						
1	Гудамжны гэрэл	ш	6	119,000	714,000	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон
2	Өнгөт принтер	ш	1	100,000	100,000	
3	Зургийн аппарат	ш	1	307,350	307,350	
4	Тог баригч	ш	1	150,000	150,000	
5	Пульс оксиметр	ш	1	327,794,9	327,794,9	
6	Жижиг мэс заслын иж бүрдэл	ш	1	694,153,8	694,153,8	
7	Вакцины хөлдөөгч	ш	1	590,233	590,233	
8	Хөгжим	ш	1	25,000	25,000	
9	Отсос	ш	1	275,000	275,000	
10	Солюкс	ш	2	7570,5	15,141	
11	Эх хүүхдийн багц жин	ш	1	60,000	60,000	
	Дүн				3258,672,7	
Эм эргэлтийн сан						
1	Компьютер	ш	1	450,000	450,000	Шатсан
	Дүн				450,000	



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 04

Хажуу шинэ үс

“Алдарт эх” одонгоор шагнуулах
тухай

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, Ерөнхийлөгчийн 2011 оны 116 дугаар зарлигаар баталсан Эхчүүдийг “Алдарт эх” нэг, хоёрдугаар одонгоор шагнах журмыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Дөрвөн хүүхэд төрүүлж өсгөн хүмүүжүүлсэн тус сумын харьяат 5 эхчүүдийг “Алдарт эх” хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулахаар нэрсийг хавсралтаар баталж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2. Эхчүүдийн холбогдох материалыг журмын дагуу бүрдүүлж, хугацаанд нь хүргэхийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Д.Жаргалмаа)-д үүрэг болгосугай.



ДАРГА, *[Signature]* В.НЯМСҮРЭН

040010

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 01 сарын 31-ны өдрийн
04 дүгээр тогтоолын хавсралт

ГОВЬ-УГТААЛ СУМААС 2018 ОНД "АЛДАРТ ЭХ" 2 ДУГААР
ОДОНГООР ШАГНАГДАХ ЭХЧҮҮДИЙН НЭРС

№	Овог	Нэр	Ажил, албан тушаал
1	Даанинцадмид	Баасансүрэн	Дунд сургуульд багш
2	Балбармаа	Жаргалмаа	3-р багт малчин
3	Мөнхжаргал	Нандинцэцэг	1-р багт малчин
4	Баттөмөр	Цэрэнням	2-р баг, Ажилгүй
5	Сүрэндаваа	Эрдэнэмөнх	3-р багт малчин

040010



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 05

Хажуу шинэ ус

Цалинг шинэчлэн батлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ний өдрийн 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга В.Нямсүрэнгийн албан тушаалын сарын үндсэн цалинг 934266 (Есөн зуун гучин дөрвөн мянга хоёр зуун жаран зургаан) төгрөгөөр шинэчлэн баталсугай.

2. Үндсэн цалин, төрийн албан хаагчдад олгодог нэмэгдлүүдийг холбогдох заавар журмын дагуу тооцож 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг нягтлан бодогч (П.Алтансарнай)-д зөвшөөрсүгэй.



ДАРГА

В.НЯМСҮРЭН

480219013



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 06

Хажуу шинэ үс

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг
зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь заалтуудыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ НЬ :


1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах сумын орон тооны бус зөвлөлийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга	Сумын ИТХ-ын дарга
Орлогч дарга	Сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга	ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
Гишүүдэд:	Засаг даргын тамгын газрын дарга
	1 дүгээр багийн Засаг дарга
	2 дугаар багийн Засаг дарга
	3 дугаар багийн Засаг дарга
	4 дүгээр багийн Засаг дарга
	Дунд сургуулийн захирал
	Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
	Соёлын төвийн эрхлэгч
	Нийгмийн бодлогын ажилтан
	Хэсгийн мөрдөгч
	Сургуулийн нийгмийн ажилтан
	Ахмадын хорооны дарга
	Сурагчдын төлөөлөл

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн талаар улирал тутам ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнахыг зөвлөлийн дарга-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 09 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  В. НИЯМСҮРЭН



480219015



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 04

Хажуу шинэ ус.

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйл
ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ НЬ :

1. Говь-Угтаал сумын мал сүргийг 2019 онд шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Эмчлэн сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу чанартай хариуцлагатай хийж гүйцэтгэхийг "Угтаал чандмань" хоршоонд үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж холбогдох байгууллагад тухай бүр тайлан мэдээг хүргүүлж хэрэгжилтийг ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнахыг сумын мал эмнэлгийн тасагт даалгасугай.



ДАРГА *В.НЯМСҮРЭН* В.НЯМСҮРЭН

480210010

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 07 сарын 27-ны өдрийн
07 дугаар тогтоолын хавсралт

ГОВЬ-УГТААЛ СУМЫН МАЛ СҮРГИЙГ 2019 ОНД ШИМЭГЧТЭХ
ӨВЧНӨӨС ЭМЧЛЭН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Баг болон МЭҮН нэр	Ширхтэх, хамруулах угаалга			Хорхойгүйтгэх					Гадна шимэгчтэх, гууртах боловсруулалт					Өрхийн тоо	Хамрагдах мал					
		Бог	Тэмээ	Бүгд	Бог	Адуу	Тэмээ	Нохой	Бүгд	Бог	Адуу	Тэмээ	Үхэр	Бүгд		Бүгд	Бог	Адуу	Тэмээ	Үхэр	Нохой
1	Угтаал чандман хоршоо	15000	0	15000	10000	500	0	250	10750	20000	500	50	500	21050	200	11250	10000	500	0	500	250
ДҮН		15000	0	15000	10000	500	0	250	10750	20000	500	50	500	21050	200	11250	10000	500	0	500	250

ГОВЬ-УГТААЛ СУМЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ТАСАГ



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 08

Хажуу шинэ ус

Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг
батлах тухай

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ НЬ :

1.Хамтарсан багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Багийн ахлагч	Сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга	Сургуулийн нийгмийн ажилтан
Гишүүдэд:	Хүүхдийн элч
	Нийгмийн бодлогын ажилтан
	Сургуулийн захирал
	1 дүгээр багийн Засаг дарга
	2 дугаар багийн Засаг дарга
	3 дугаар багийн Засаг дарга
	4 дүгээр багийн Засаг дарга
	Хэсгийн мөрдөгч
	Сум дундын эмнэлгийн хүүхдийн эмч
	Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
	Сургуулийн эмч
	Хөдөлмөр халамжийн мэргэжилтэн
	Дотуур байрны багш

2. Сумын хамтарсан багийн ажиллах журмыг боловсруулан батлуулж мөрдөж ажиллах, жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн талаар хагас, бүтэн жилээр ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнахыг хамтарсан багийн дарга-д үүрэг болгосугай.

ДАРГА



В. НИЯМСҮРЭН

480219021



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 09

Хажуу шийнэ ус

ITX-ын ажлын албаны хөдөлмөрийн
дотоод журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2 дахь заалтуудыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сумын ИТХ-ын ажлын албаны хөдөлмөрийн дотоод журмыг хавсралтаар баталсугай.

3. Хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Д.Жаргалмаа)-д үүрэг болгосугай.



ДАРГА *В.Н.Н.Н.* В.НЯМСҮРЭН

480219023



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр

Дугаар 10

Хажуу шинэ үс

Чоймчигийн Галсандоржийг "Хөдөлмөрийн гавьяаны
Улаан тугийн одон"-гоор шагнуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журмын 12-ын "Г", Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дах заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ НЬ :

1.Тус сумын 2 дугаар багийн иргэн Чоймчигийн Галсандоржийг сум орон нутагт олон жил үр бүтээлтэй ажилласан хөдөлмөр бүтээлийг нь үнэлж "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-гоор шагнуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2.Тодорхойлолт материалуудыг холбогдох журам зааврын дагуу бүрдүүлж, хүргүүлэхийг сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.



ДАРГА

В.НЯМСҮРЭН

480219025



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 11

Хажуу шинэ ус

Баянмөнхийн Цэрэнмөнхийг “Алтан гадас” одонгоор шагнуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журмын 12-ын “Г”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дах заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ нь :

1.Тус сумын Угтаал чандмань хоршооны менежер Баянмөнхийн Цэрэнмөнхийг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг төлөвшүүлж, тогтворжуулах ажилд олон жил идэвхи санаачлагатай ажиллаж, сум орон нутгийн хөгжлийн төлөө оруулсан хувь нэмэр, хийж бүтээсэн ажлын амжилтыг үнэлж Монгол Улсын төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор шагнуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2.Тодорхойлолт материалыг аймгийн ИТХ-ын ажлын албанд хүргүүлэхийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Д.Жаргалмаа)-д үүрэг болгосугай.



ДАРГА *[Signature]* В.НЯМСҮРЭН

480219028



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 12.

Хажуу шинэ ус

Долдойн Намжилдоржийг "Алтан гадас"
одонгоор шагнуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журмын 12-ын "Г", Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дах заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаас ТОГТООХ НЬ :

1.Тус сумын 2 дугаар багийн иргэн Долдойн Намжилдоржийн хөдөө аж ахуйн нэгдлийн нягтлан бодогчоор олон жил үр бүтээлтэй ажилласан хөдөлмөр бүтээлийг нь үнэлж Монгол Улсын төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор шагнуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2.Тодорхойлолт материалыг аймгийн нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлэхийг сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА  В.НЯМСҮРЭН

